



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/631

Булган сум

┌ Самбо бөхийн насанд хүрэгчдийн ┐
дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох
тамирчдад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.9 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны "Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай" IV/25 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны "Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардал батлах тухай" А/360 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүгд Найрамдах Киргиз Улсын Бишкек хотод 2025 оны 11 дүгээр сарын 05-06-ны өдрүүдэд зохион байгуулагдах самбо бөхийн насанд хүрэгчдийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд аймаг, орон нутгаа төлөөлөн оролцох тамирчин Д.Пүрэвдоржийн замын зардалд 2,600,000 (хоёр сая зургаан зуун мянга), Э.Гансүхийн замын зардалд 2,500,000 (хоёр сая таван зуун мянга) төгрөгийн дэмжлэг тус тус үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг Засаг даргын хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

0325010883